



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот


Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах
бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 14/06 дугаар зөвлөмж болон Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 113 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Газрын тос боловсруулах үйлдвэрүүдийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Газрын тосны үйлдвэрүүдийн урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэх зөвлөх компанийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллуулах, санхүүжилтийг Хөгжлийн банкны холбогдох журмын дагуу шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүүд даалгасугай.

Гурав. Газрын тосны үйлдвэрүүдийн урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Ажлын даалгаврыг 2015 оны 4 дүгээр сарын 15-ны дотор, газрын тосны үйлдвэрүүдийн урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүнг 2015 оны 8 дугаар сарын 31-ний дотор танилцуулахыг Ажлын хэсгийн дарга Д.Нямхүүд үүрэг болгосугай.

САЙД  ДЭРДЭНЭБАТ